

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын насан туршийн боловсролын төвийн 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн  
аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 70433061  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас:70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Эл Би Альфа аудит ХХК-ны  
аудитор: Н.Дэмбэрэлдорж  
Утас: 99299027  
цахим хаяг: ndembee9929@gmail.com.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	9
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт .....	10
4.1 Залруулсан алдаа .....	10
4.2 Төлбөрийн акт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Албан шаардлага .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Зөвлөмж.....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил
ТШЗ	Төсвийн шууд захирагч

ЖАРГАЛАНТ СУМЫН НАСАН ТУРШИЙН  
БОЛОВСРОЛ ТӨВИЙН ЕРӨНХИЙ  
МЕНЕЖЕР Ц.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын насан туршийн боловсрол төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын насан туршийн боловсрол төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,942,338.51</u></b>	<b><u>4,741,825.36</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,678,725.00	4,678,725.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>4,678,725.00</b>	<b>4,678,725.00</b>
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	4,678,725.00	4,678,725.00
35440	Түлш, шатах тослох материал		
35470	Бусад хангамжийн материал		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,814,842.86</u></b>	<b><u>10,483,144.02</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,594,842.86	10,483,144.02
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,143,261.00	30,143,261.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,482,036.20)	(29,195,761.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,180,743.00	21,818,743.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,247,124.94)	(12,283,098.62)
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	220,000.00	220,000.00
39301	Программ хангамж	330,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(110,000.00)	(110,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>11,757,181.37</u></b>	<b><u>15,444,969.38</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>9,613,696.38</u></b>	<b><u>14,475,069.38</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	9,613,696.38	14,475,069.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,613,696.38	14,475,069.38
51210	Өмнөх үеийн үр дүн	9,613,696.38	9,613,696.38
51220	Тайлант үеийн үр дүн	-	4,861,373.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>10,473,181.37</u></b>	<b><u>14,475,069.38</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>105,773,000.00</b>	<b>111,926,200.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		
<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>5,638,000.00</b>
Төсөв байгууллагын өөрийн орлого		

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		5,638,000.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	105,773,000.00	106,288,200.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,773,000.00	106,288,200.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	107,383,473.23	107,064,827.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	107,383,473	107,064,827.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	105,973,473.23	106,328,727.00
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	90,689,506.00	89,240,446.00
Үндсэн цалин	62,227,807.00	67,022,783.00
Нэмэгдэл	23,860,982.00	17,424,687.00
Унаа хоолны хөнгөлөлт		
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,804,239.47	11,131,782.16
Тэтгэврийн даатгал	7,708,608.04	8,090,313.22
Тэтгэмжийн даатгал	2,246,545.98	2,206,241.67
ҮОМШӨ-ний даатгал	725,516.05	713,923.55
Ажилгүйдлийн даатгал	123,569.40	121,303.72
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,718,707.00	1,030,000.00
Бичиг хэрэг	134,400.00	89,000.00
Тээвэр, шатахуун	100,000.00	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578,200.00	714,900.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,850.00	87,500.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	65,600.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	891,257.00	73,000.00
Урсгал засвар	1,718,707.00	1,030,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	48,000.00	9,900.00
Дотоод албан томилолт	48,000.00	9,900.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2504560.76	2939448.84
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1365060.76	1749698.84
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1365060.76	1749698.84
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	105773000	106288200
Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-1610473.23</b>	<b>4861373.00</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	768900	11224169.61	11993069.61
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	768900	11224169.61	11993069.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	768900	11224169.61	11993069.61
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	5638000	-	5638000
D08	Тайлант үеийн үр дүн	-	4861373.00	4861373.00

D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6406900	14475069.38	15243969.38
-----	---------------------------------------	---------	-------------	-------------

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>105773000</b>	<b>106288200</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>105773000</b>	<b>106288200</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	105773000	106288200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105773000	106288200
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>105773000</b>	<b>106288200</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>105773000</b>	<b>106288200</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>103575500</b>	<b>102342100</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	88090400	88313300
210101	Үндсэн цалин	62145500	61585000
210102	Нэмэгдэл	18167000	21527600
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7777900	5200700
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11892200	11127700
210201	Тэтгэврийн даатгал	8425700	7623200
210202	Тэтгэмжийн даатгал	866500	876100
210203	ҮОМШӨ-ний даатгал	693200	700900
210204	Ажилгүйдлийн даатгал	173300	175200
210205	Эрүүл мэндийн даатгал	1733500	1752300
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1152700	1086300
210401	Бичиг хэрэг	92400	89000
210402	Тээвэр, шатахуун	100000	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	628700	718300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65600	65600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73400	73400
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	453500	254000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	163500	163500
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал-эм бэлдмэл</b>	290000	90500
210601	Багаж, техник, хэрэгсэл-ном хэвлэл	192600	140000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар		
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>48000</b>	<b>9900</b>
210702	Дотоод албан томилолт	48000	9900
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1938700	1550900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1938700	1550900
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2197500</b>	<b>3946100</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2197500	3946100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	106288200	106288200
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	106288200	106288200
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	99883500	102342100
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	85253300	88313300
210101	Үндсэн цалин	60885000	61585000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11509100.00	11127700.00
210201	Тэтгэврийн даатгал	8099000.00	7623200.00
210202	Тэтгэмжийн даатгал	852500.00	876100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	682000.00	700900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	170500.00	175200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1705100.00	1752300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1086300.00	1086300.00
210401	Бичиг хэрэг	89000.00	89000.00
210402	Тээвэр, шатахуун	86200.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	632100.00	718300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73400,00	73400,00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал-ном хэвлэл</b>	140000,00	140000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл-хог хаягдал	65000,00	65600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	163500,00	163500,00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	229900,00	9900,00
210702	Дотоод албан томилолт	229900,00	9900,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8046100,00	5587500,00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	106288200,00	106288200,00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	106288200,00	106288200,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	106288200,00	106288200,00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	0
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	7	7
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4
620003	Үйлчлэх ажилтан	1	1
620004	Гэрээт ажилтан	0	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0	0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	0	0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын насан туршийн боловсрол төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд и баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Эл Би Альфа Экспэйншин аудит ХХК-ны Аудитор Н.Дэмбэрэлдорж 2022 оны 02 дугаар сарын 1-нээс 2021 оны 02 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын ХА насан туршийн боловсрол төв нь дүйцсэн хөтөлбөрийн хүрээнд сургууль завсардсан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон эрх нь хязгаарлагдсан зарим иргэд, цэргийн алба хааж байгаа бичиг үсгийн боловсрол эзэмшиж чадаагүй иргэдэд амьдрах ухаан ур чадвар, гэр бүлийн боловсрол, гоо зүйн боловсрол, иргэний эрх зүйн боловсрол, насанд хүрэгчдийн бичиг үсгийн болон шинжлэх ухаан технологийн танин мэдэхүйн анхан шатны боловсрол, сургалтыг зохион байгуулж удирдлага арга зүйгээр хангах, чиг үүрэгтэй үйл ажиллагааны явуулж байна .

Аймгийн НТБ-ийн төв 7 орон тоотой, Булган сумын НТБТ нь 6 орон тоотой, бусад сумдад 15 багш, нийт 28 багш ажилтан ажиллаж байна.

Боловсрол, Шинжлэх ухааны яамнаас дэвшүүлсэн 2020-2021 оны хичээлийн жилийн “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахууд тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго”-ын хүрээнд дараах 5 зорилтыг дэвшүүлж хэрэгжилтийг ханган ажиллаа. Үүнд:

- “Ковид 19” цар тахалаас үүдэлтэй сургалт, хүмүүжлийн ажлын хүндрэлийг даван туулах бодлого хэрэгжүүлэх”
- БШУЯС-ын 2020 оны А/99 тушаалын хэрэгжилтийг хангаж “Боловсрол нөхөн олгох хөтөлбөр”-ийн сургалт зохион байгуулах
- БСШУ-ны сайдын 2013 оны А/242 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.5 заалтын “Сургалтын агуулга”-ын хэрэгжилтийг хангаж насанд хүрэгчдийн сургалтыг зохион байгуулах
- Аймгийн насан туршийн боловсролын боловсон хүчнийг чадавхжуулах зорилтыг хэрэгжүүлэх
- Гадаад, дотоод харилцааны олон талт үйл ажиллагааг дэмжих, хэрэгжүүлэх

Жаргалант сумын төвд 60 суралцагч байна. Үүнээс танхимын сургалтад 31 сурагч, зайгаар буюу эчнээ ангид 29 сурагч суралцаж байна. Тусгай хэрэгцээтэй 14 суралцагч байна. Энэ хичээлийн жилд аймгийн төвийн боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн холимог бүлгийн дунд бүлгээс 3 сурагч ЕБС-д шилжүүлэн суралцуулсан болно. Аймгийн хэмжээнд дүйцсэн сургалтын хөтөлбөрөөс ердийн сургалтад 9 хүүхэд шилжин суралцсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын насан туршийн боловсрол төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “сайн” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 111926,2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1,1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 0,9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Жаргалант сумын насан туршийн боловсрол төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3687,8 мянган төгрөгөөр буюу 31,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 1888,0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн зарцуулж, оны эхний үлдэгдэл 4678,7 мянган төгрөгийн аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан байна,

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 46654,0 мянган төгрөг байсан бол оны эцэст 52292,0 мянган төгрөг болж, 5638,0 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 9 нэрийн хөрөнгийг БШУЯ-аас үнэ төлбөргүй олгосонтой холбоотой байна.

Тайлант онд 5638,0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, акталж устгасан хөрөнгөгүй ба тайлант оны эцэст 52292,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 11993,1 мянган төгрөг байсан оны эцэст 15244,0 мянган төгрөг болж, тайлант онд 3250,9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 4861,4 мянган төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Жаргалант сумын насан туршийн боловсрол төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 106288,2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 106288,2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

БСШУ-ны яамнаас тус байгууллагын төсвийг 106288,2 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 106,288,2 мянган төгрөгийн төсөв баталснаас 106,288,2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 106288,2 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 106288,2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 106288,2 мянган төгрөг буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 99441,0 мянган төгрөг, бараа хангамж, бараа материалын зардал 1086,3 мянган төгрөг, томилолтын зардал 9,9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5751,0 мянган тус тус зарцуулсан байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн орлого байхгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан нь 139 мэдээлэл байна. хугацаа хоцроосон мэдээлэл 12 байна. цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12, зарлагын 0 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна..

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ӨМНӨХ АУДИТААР 2 ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БӨГӨӨД 100 ХУВЬ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар и баримтын бүрдүүлэлттэй холбоотой 1 зөвлөмжийг өгсөн болно.

#### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.1 Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа N баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг N баримтаар баталгаажуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын насан туршийн боловсрол төв	1	0	0	0	0	0	0	0	1	0

### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

### ТАЙЛАНГ БИЧСЭН

ЭЛ БИ АЛЬФА ЭКСПЭЙНШИН АУДИТ ХХК-НЫ

АУДИТОР:

Н.ДЭМБЭРЭЛДОРЖ